



БАТЛАВ. УХТЭ-ийн ерөнхий захирал

С.Энхболд

**ЭМНЭЛГИЙН БОЛОН АХУЙН ХОГ ХАЯГДАЛ  
ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ, ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛЫН  
МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Улаанбаатар  
2020-05-22

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

ЭМНЭЛГИЙН БОЛОН АХУЙН ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ,  
УСТГАХ, ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛЫН МАТЕРИАЛ ХУДАЛДАН  
АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ  
УХТЭ/2020

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**Улсын хоёрдугаар төв эмнэлэг** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нормын хувцас, даавуу** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийг 10:00 цагаас өмнө УХТЭ-ийн Төв байрны 115 дугаар өрөө-Халдвар судлаач эмчийн өрөө, утасны дугаар 99828999** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10:30 цагт** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**УХТЭ, БЗД-ийн 3-р хороо Энхтайваны өргөн чөлөө-49, Төв байрны 115 тоот өрөө-Халдвар судлаач эмч, 99828999**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;<b>2018, 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан/</b></p> <p>Сүүлийн [2] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг:<b>УХТЭ, БЗД 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-49</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: УХТЭ-ийн Төв байрны 1-д давхар 115 дугаар өрөө-Халдвар судлаач эмчийн өрөө</p> <p>Огноо: <b>2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10:00 цаг</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</b></li> <li>2. <b>Бараа нийлүүлэх эрх бүхий улсын бүртгэлийн гэрчилгээ</b></li> <li>3. <b>Тендерт оролцогчыг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлэх</b></li> <li>4. <b>Монгол хэлнээс өөр хэлээр байвал заавал баталгаат орчуулгын газраар орчуулсан байх,</b></li> <li>5. <b>Барааг үйлдвэрлэгчээс шууд нийлүүлэхээр олгосон эрх, зөвшөөрөл, гэрээ</b></li> <li>6. <b>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн 2 жилийн туршлагын мэдээлэл ирүүлэх</b></li> <li>7. <b>Оролцогч нь харъяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэсээс 2020 оны 04 сарын 30-ний байдлаар гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулсан тодорхойлолт авч хавсаргасан байна.</b></li> <li>8. <b>Тендерт санал болгож байгаа бараа, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас чанарыг тодорхойлсон дүгнэлт</b></li> <li>9. <b>2018, 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан</b></li> <li>10. <b>Сүүлийн 2 жил гүйцэтгэгчээр ажилласан гэрээний жагсаалт</b></li> <li>11. <b>Тендерт санал болгож байгаа бараа, бүтээгдэхүүний дээж, загвар</b></li> </ol>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц 2 Цэвэрлэгээний багаж</b> <b>Багц 5 Аюулгүй хайрцаг</b> <b>Багц 6 Хогны уут</b> <b>Багц 7 Ахуйн хог хаягдал тээвэрлэх устгах</b> <b>Багц 9 Эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх, устгах</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Бараа тус бүрийн техникийн тодорхойлолтыг ар талд нь бичсэн болно.
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.]* гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** Нийлүүлэх барааны сав баглаа боодол нь стандартын шаардлага хангасан, урагдаж цоороогүй, гэмтээгүй% сав баглаа боодол нь задраагүй байна.
4. **Бараа хүргэх газар:** УХТЭ-ийн аж ахуйн нярав
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

д/д	Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
								(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8	
<b>Багц 2 .Цэвэрлэгээний багаж</b>								
1	Хос хувинтай тэргэнцэр /улаан, цэнхэр хувинтай, шал арчигчтай/	Дөрвөлжин хэлбэртэй, улаан ба цэнхэр өнгөтэй, гэрэлтэхгүй хуванцар материалаар хийгдсэн хувинтай, 4 дугуйтай, алчуур мушгигчтай, шал угаах зориулалтын алчуурын хамт байна.	8	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
2	Шал арчигчтай хувин /2 тасалгаатай/	Дөрвөлжин хэлбэртэй, улаан ба цэнхэр өнгөтэй, гэрэлтэхгүй хуванцар материалаар хийгдсэн зузаан хос хувин	10	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
3	Хос хувин 8л /улаан, цэнхэр/	Дөрвөлжин хэлбэртэй, гэрэлтэхгүй хуванцар материалаар хийгдсэн байна.	10	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
4	Хувин 5 л /хана угаах/	Дөрвөлжин хэлбэртэй, гэрэлтэхгүй хуванцар материалаар хийгдсэн байна.	50	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
5	Тавцантай шат /эвхэгддэг/	3 метраас багагүй хэмжээгээр сунадаг, устай хуван сав тавих зориулалтын тавцантай. Бат бөх чанартай байх.	2	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
6	Гарын цаасны сав	Хуруугаар дарж онгойлгойдог түлхүүргүй, угааж халдваргүйтгэхэд боломжтой хуванцар материалаар хийгдсэн. Хэрэглэхэд хялбар, цайвар өнгөтэй байна.	150	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
7	Шпатель	Шалны будаг, бохь арилгах зориулалттай төмрөөр хийгдсэн, хуванцар бариултай.	30	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	

8	Шалны мод	Яргүй хуурай модоор хийгдсэн, толгойны урт нь 50см, ишний урт нь 140-150см, ишний бүдүүн нь 3-4см, барихад эвтэйхэн, хөнгөн байна.	80	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
9	Зөөлөн эдлэл зөөвөрлөх тэргэнцэр	100 кг-аас багагүй багтаамжтай, даац сайтай, даацын, тоормозтой, чөлөөтэй эргэдэг дугуйнуудтай байна. Угааж халдваргүйтгэхэд тохиромжтой материал бүхий байна.	5	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
10	Тосгууртай хогийн шүүр	Шүүрний үс нь хатуу, ширүүн хог сайн авдаг байна. Тосгуур нь хогийн шүүрний хамт байна.	50	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
11	ОО цэвэрлэх сойзны иж бүрдэл	ОО угаах зориулалт бүхий, угааж халдваргүйтгэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна. Хуванцарын агууламж нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд хоргүй байна.	200	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
12	Хогийн сав	20 литрээс багагүй хэмжээтэй, угааж халдваргүйтгэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна. Хогийн сав нь шингэн нэвчихгүй, хуванцар, металл зэрэг материалаар хийгдсэн зузаан, бат бөх, таглаатай, хөлөөр дарж онгойлгодог байна.	50	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	

**Багц 5. Аюулгүй хайрцаг**

	Хуванцар аюулгүй хайрцаг (1л)	Заасан хэмжээнээс багагүй хэмжээтэй, зүү, хурц ирмэгтэй зүйл устгах зориулалт бүхий шингэн нэвчдэггүй биологийн аюулгүй гэсэн тэмдэг бүхий сэнжтэй хуванцар шар өнгөтэй сав байна.	1500	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
	Хуванцар аюулгүй хайрцаг (2л)	Заасан хэмжээнээс багагүй хэмжээтэй, зүү, хурц ирмэгтэй зүйл устгах зориулалт бүхий шингэн нэвчдэггүй биологийн аюулгүй гэсэн тэмдэг бүхий сэнжтэй хуванцар шар өнгөтэй сав байна.	2300	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
	Аюулгүй хайрцаг /Цаасан/	MNS-5525 стандартын шаардлага хангасан, ус, цус, биологийн шингэн, зүү, хурц ирмэгтэй зүйл нэвтрэхээргүй, дотор тал нь гялгар уутан доторлогоотой, гадна талдаа дүүргэх хэмжээг заасан улаан зураастай, био аюулгүйн тэмдэгтэй, 5 л-ээс багагүй хэмжээтэй байна.	3000	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	

**Багц 6. Хогны уут**



1	Хар уут (жижиг-60*35 см-ээс багагүй)	ISO 7765:2004 стандартын шаардлага хангасан. Амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчихгүй, хлор агуулаагүй нийлэг материалаар хийгдсэн байна. 7 микроноос багагүй зузаантай байна. Ус үл нэвтрэх, 3 кг-аас багагүй даацтай, амыг нь уях боломжтой, уутны гадна талд зохих тэмдэглээтэй, 1 боодолд байх тоо нь бүрэн гүйцэд байх ба заагдсан хэмжээтэй байна. Халдвартай, эмгэг, хурц үзүүртэй хог хаягдлын уут, сав нь шар өнгөтэй, эмийн болон эсэд нөлөөтэй, химийн, цацраг идэвхит хог хаягдлын уут хүрэн өнгөтэй байна. Уутны гадна талд хог хаягдлын шинж чанараас хамаарч тусгайлсан "Биоаюултай" таних тэмдгүүдийг харагдахуйц өнгөөр, томоор хэвлэсэн байна.	30000	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
2	Хар уут (дунд-70*45 см-ээс багагүй)		50000	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
3	Хар уут (том-80*50 см-ээс багагүй)		2700	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
4	Шар уут (дунд-70*45 см-ээс багагүй)		55000	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
5	Шар уут( том-80*50 см-ээс багагүй )		2200	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
6	Хүрэн уут (жижиг-60*35 см-ээс багагүй)		200	ширхэг	Аж ахуйн агуулах	6/5/2020	12/31/2020	
<b>Багц 8. Ахуйн хог хаягдал тээвэрлэх, устгах</b>								
1	Хог тээврийн зардал	1 рейсийг 5 тн-оор тооцох ба ирэхдээ хоосон ирж ачна.	84	удаа		6/5/2020	12/31/2020	
<b>Багц 9. Эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх, устгах</b>								
1	Тээвэрлэлт устгалын зардал	7 хоногт 3-оос багагүй удаа ирж тээвэрлэнэ. Зориулалтын саваар тээвэрлэнэ.	100	удаа		6/5/2020	12/31/2020	

## БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

5/22/2020

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	2020 он	Сарууд											
				I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
<b>Багц 2. Цэвэрлэгээний багаж</b>															
1	Хос хувинтай тэргэнцэр /улаан, цэнхэр хувинтай, шал арчигчтай/	ширхэг	8						8						
2	Шал арчигчтай хувин /2 тасалгаатай/	ширхэг	10						10						
3	Хос хувин 8л /улаан, цэнхэр/	ширхэг	10						10						
4	Хувин 5 л /хана угаах/	ширхэг	50						50						
5	Тавцантай шат /эвхэгддэг/	ширхэг	2						2						
6	Гарын цаасны сав	ширхэг	150						150						
7	Шпатель	ширхэг	30						30						
8	Шалны мод	ширхэг	80						80						
9	Зөөлөн эдлэл зөөвөрлөх тэргэнцэр	ширхэг	5						5						
10	Тосгууртай хогийн шүүр	ширхэг	50						50						
11	ОО цэвэрлэх сойзны иж бүрдэл	ширхэг	200						200						
12	Хогийн сав	ширхэг	50						50						
	Нийт дүн														
<b>Багц 5. Аюулгүй хайрцаг</b>															
1	Хуванцар аюулгүй хайрцаг (1л)	ширхэг	1500	125	125	125	125	125	125	125	125	125	125	125	125
2	Хуванцар аюулгүй хайрцаг (2л)	ширхэг	2300	190	190	190	190	190	190	190	190	190	190	200	200
3	Аюулгүй хайрцаг /Цаасан/	ширхэг	3000	250	250	250	250	250	250	250	250	250	250	250	250
	Нийт дүн														
<b>Багц 6. Хогны уут</b>															
1	Хар уут (жижиг)	ширхэг	30000	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500
2	Хар уут (дунд)		50000	4150	4150	4150	4150	4150	4150	4150	4150	4150	4200	4200	4200

3	Хар уут (том)		2700	225	225	225	225	225	225	225	225	225	225	225	225
4	Шар уут (дунд)		55000	4550	4550	4550	4550	4600	4600	4600	4600	4600	4600	4600	4600
5	Шар уут( том )		2200	180	180	180	180	185	185	185	185	185	185	185	185
6	Хүрэн уут		200					100			100				
	Нийт дүн														
<b>Багц 8. Ахуйн хог хаягдал тээвэрлэх устгах</b>															
1	Хог тээврийн зардал	рейс	84	7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
<b>Багц 9. Эмнэлгийн хог хаягдал тээвэрлэх, устгах</b>															
1	Тээвэрлэлт устгалын зардал	рейс	100	8	8	8	8	8	8	8	8	9	9	9	9
	Бүгд														

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.5%**
- Алдангийн нийт дүн:

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*